



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/98

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32.1.3, 32.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хуурайшилтын улиралтай холбогдуулан сумын нийт иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх түүнчлэн иргэд олон нийтийг болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах, брошюр материал тараах зэрэг нөлөөллийн үйл ажиллагааны зардалд зориулж 3 272 500 (гурван сая хоёр зуун далан хоёр мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг сумын гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ХАТАНБААТАР

Батлав.

ДАРГА

Н.ХАТАНБААТАР

**ГАМШГИЙН ЭРСДЛИЙГ БУУРУУЛАХ, ЭРСДЛЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2025.04.10

Мөрөн сум

1. Зорилго

Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтийг гамшгийн нэрвэгдэлтийн үед авах арга хэмжээний ойлголттой болгох, иргэд төрийн байгууллагын хоорондын харилцааг гамшгийн эрсдлийн үед сайжруулах арга хэмжээг тодорхойлох.

2. Үндэслэл

Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол улсын Шадар сайдын

3. Хамрах хүрээ

Сумын Зөөлөн, Өлзийт, Бүрээт, Цагаан толгой, Чандган багт оршин суудаг нийт иргэд

Хамрах асуудлууд:

- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх
- Тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- Иргэд олон нийтийн гамшгийн эрсдлийн үе дэх оролцоо
- Бусад

4. Хугацаа

Эхлэх огноо: 2025 оны 03 дүгээр сарын 13

Дуусах огноо: 2025 оны 06 дугаар сарын 13

Нийт үргэлжлэх хугацаа: 90 хоног

7. Шалгалтын дүнг танилцуулах

Иргэд олон нийтийн оролцооны дүнг нэгтгэн дүгнэж, 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Засаг даргын зөвлөлд тайлагнах бөгөөд цаашид сайжруулах зөвлөмж, арга хэмжээ боловсруулна.